

## ДЭЛ ХӨНЖЛИЙН ТҮҮХ-СОЁЛЫН ДУРСГАЛ

Д.Хүүхэнбаатар

Монгол Улсын Их Сургууль, Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль, Түүхийн тэнхим

**Өгүүллийн товч утга:** Бүр хүрлийн үеэс амьдарч, солигдож гайхамшигт баялаг дурсгал үлдээснийг судалгааны хялбарчил маягаар тоймлов.

**Түлхүүр үг:** Дэл уул, баруун зүүн билүүн.

Би говийн малчин хүүхэд. Хад яж дуулж, уйлж, хувилахыг нь шүтэн түүх соёлын ямар их үнэт дурсгал болохыг өчүүхэн бага хүүхэд хэрхэн мэдэх билээ. Гэлээ ч зөн совингоороо ч гэх юм уу өдөр болгон уулзан учирч дуулж уйлж, хувирч хувьсах нь шүтсээр байсан. Үүнийг бага бандийн толгой дэл уулаа түүх соёлын нандин дурсгалт газар болохыг хэрхэн төсөөлөх вэ? 1911 оноос 1921 оныг хүртэл Түшээт хан аймгийн Говь түшээ гүний хошуу тайж Мэрэг ахайн албат хэсэг Жавзандамбын шинэ шавь, Дөч баг гэсэн үндсэн хэсгүүдээр Өлзийт сумын голомт бий болсон байна.

Өлзийт сум 2004 онд 1924 оны хулгана жил байгуулагдсаны 80 жилийн ойгоо ёслол төгөлдөр тэмдэглэлээ. Би Өлзийт сумын түүхээс дурьдахын учир нь энэ онд Богд хан уулын Өлзийт сумыг Сүрэнхор занги даргалан Өвөрдээрсэн усанд анх байгуулжээ. Дэл уул энэ сумын хамгийн өмнөт хэсэгт оршдог сум нь Дундговь аймгийн нутаг дэвсгэрийн тавны нэгтэй тэнцдэг өргөн уудам нутаг.

Дэлийг орших байршлын нь үгээр зураглавал араараа Тагтын хэцийн уулстай залгана. Тагт Муруй цагаан сүүж, Хөх шанд, Цагаан тээг, Дарцагт ямаагийн хар, хэцүү тээг үргэлжлэн алдарт Цагаан суврага гээд говийн хонхор газрын уулстай. Энэ нутаг эрт олон сая жилийн өмнө, далайн ёроол байсан бололтой. Их, бага хайрхан /шохой/ хонхорын хойт дээр цайвалзан харагдаж үзэсгэлэн нэмнэ.

Дэлд Алаг хяр, Хүрэн овоо, Босгын гашууны хонхор, Тэвш хадан нь усны хяраар говийн намхан мөртлөө хэцүү уулсууд торолзоно. Тиймээс ч хэцүү, бэрх гэж дуртай амьтан даваад гарчихаж чадахгүй, цөөхөн хэдэн хадан босгоор нэвтэрнэ. Дэл уул нь Дэлийн үзүүр Хар тээг, Алагийн хэц, Авдрант, Цагаан чулуут, түүний хонхор, Шар хошууны хяр, Хамар усны хяр, Харанхуйн ам, Зүүн Баруун билүүний хад, Сухай жирэмийн ам үргэлжилсээр шувтарч Цагаан суврагын бараа баруун хойно харагдана. Чулуун сүмийн говийн цаана Их, бага Буюнтын хоёр уул торойж, хөнжлийн уул цэнхэртэнэ. Дэл хөнжлийн говийн баруун дээдэд алдарт Хонгор хайрхан гэр гэмээр алаг зандангийн агуйгаараа бишрүүлэн хүнгэнэн шуугиж дүнхийнэ. Улмаар түүнээс дэргэдээс Бэрхийн уул, Аргалын нуруу Гөлий тороин хадан хэц төгсгөлд нь Төмөртолгой гэдэг жижиг толгойгоор шувтарна.

Энэхүү байршил тогтооос сонин домог байдаг. Баянхонгор залуу эр сүйт бүсгүйдээ очихоор түрүү хоёр лам явуулаад Бэрх нэрт нохойгоо дагуулан, ачаа хөсгөө хөдөлгөх гэтэл алсад сүй тавих бүсгүйг нь цэл буурал үзэгдэхэд хайрхан бүх хөдөлгөөнийг зогсоож хөгшин байна гэж үзээд нам суужээ. Тэр нь Буурал угалз уул тэртээд цайвалзсаар байжээ. Дэл хөнжилд түүх соёлын дурсгал, тэмдэглэлт үйл явдлууд туйлын элбэг ажээ. Уулын чулуулаг нь геологийн биш хүний нүдээр харахад эр хар чулуу, шохойн чулуу, билүүн чулуунаас уулууд бие дааж тогтжээ. Бас эрдэнэ агуулсан өөхөн цагаан чулуу ч бий. Байгалийн баялаг, ан гөрөө элбэг, зээр гөрөөс сүрэглэн, Аргал янгар дүүлэн үнэг, чоно, хярс язганан байдаг нутаг байжээ.

Түүх соёлын дурсгалын хувьд эртний их өв уламжлалтай. Энэ нутаг, ард олны түүхийг шинжлэх ухааны үүднээс судалгаа эхлэн явагдаж байна. Дэл уулыг Баруун билүүний уул /ам/, "32 модон хүнт", Элст хөтөл, Зүүн билүүн,

Сухайн гэж багцаалан хувааж болно. Эдгээрт хүрлийн гэгдэг үед хамарагдах дөрвөлжин, шоргоолжин булш элбэгтэй. Засаг захиргааны зохион байгуулалтаар /1924/ Богд хан аймгийн Дэлгэрхангай уулын хошууны Өлзийт сумыг Сүрэнхор занги даргалан Өвөр дэrsэн усанд анх байгуулжээ. Тэр цагаас хойш 20 гаруй удаа нүүдэллэж "Нүүдэлчин сум" гэгдэж энэхүү Рашаантад 1965 оноос суурьшжээ.

Оюутан судлаач Жигмэддорж<sup>1</sup> Дэлийн дурсгалуудыг чулуун зэвсгийн зүйл, дөрвөлжин (шоргоолжин) булш, хадны сүг зураг гэж ангилсан байх бөгөөд бичээсийг орхин бас бэлүүдийг холбосон задгай чулуун зээглэсэн цувраа хашлага элст хөтөл, Баруун билүүний булгийн эхэнд тус тус байх бөгөөд учрыг нь тайлж чадаагүй гэсэн ч нэн эртний үед хамарагдах болохыг л хэлж чадна. Билүүнд нийтдээ 20 орчим дөрвөлжин булш бүртгэгдсэн байх бөгөөд түүнээс дөрвийг Д.Хүүхэнбаатар, В.В.Волков Т.Санжмятав, С.Бат-Эрдэнэ нар малтсан бөгөөд тайлан нь ШУА-ийн Түүхийн хүрээлэнд буй. Булшнуудын ерөнхий хэмжээ 2-2,5 м байна.

Дэлийн түүх соёлын судалгаа эхлэн явагдаж байна.<sup>2</sup> Хадны сүг зургаар гайхмаар. Эрт үеэс эдүгээг хүртэл билүүн хаднаа цоожиж цоолборлож, хүрэл төмөрлөгөөр зүсэж эсгэж бүтээсэн нь ажиглагддаг. Зүүн билүүний харалдаа зүүн биед Өлзийтийн хуудсанд сонирхолтой сүг зураг бүхий толгой бий. Тэр зурган дотор Өлзий тэмдэг байгаа нь овгийн шүтээн, тамга бололтой бодогдоно. Зүүн билүүний дээд усны баруун дэл хаданд хурц эдээр долоон өргөөний зургийг нэг дор сийлсэн нь гайхмаар. Ингэж нэг дороо опдсон өргөө гэрийн дурсгал байдгийг дуулаагүй санагдана.

Энэ долоон гэр өргөөг үзээд дээдсийн өргөө түр буудаллаж байхад зурсан байж магадгүй гэдэг санаа төрж, Их өргөө энд ав хомрого хийх зорилгоор түр saatсан байж болох юм. Энэ дурсгал их хожуу үед хамрагдах нь тодорхой. Хүйсийг онцгой ялган /хүн, адгуус амьтны/ гаргадаг нь сонин. Эр эмийн энгэр зөрүүлэх ёсыг олонт дүрсэлсэн нь нэгэн гэр бүлт ёсны бэлэг тэмдэг болгосон бололтой. Үүнийг хүмүүст хамааруулж ойлгоно гэдэгт итгэнэ. Судлаачдын үзсэнээр гэрийн ба зэрлэг амьтад гэж ангилсан байна. Гэрийн амьтдаас адуу, үхэр, нохой, ямаа байгаа нь амьдрах аж ахуй, эх булаг гэцгээсэн байна. Гэвч тэмээ, хснийг үүндээ оруулсангүй байх юм. Монголын бэлгэдэл зүйн үүднээс 5 хошуу малын бие дүрсийг хад чулуунаа үйлдсэн нь "тансаг баян аж амьдрал, малын хишиг буяныг даллан дуудсан бэлэгдэл" утгыг илэрхийлж, Дэл уулын зураглалд хүн (хүмүүс)-ийг тэдний хүсэл санаа, үйл ажиллагаа зан заншил, гоёл чимэглэл зэр зэвсгийг дүрсэлсэн нь элбэг.

Нэг хаданд чихэндээ цагираг ээмэг зүүсэн дүрс байхад негөөд 2 эр хүний маш том, бусад 11 жижиг дүрс зурагдсан бий. Баруун билүүний 2 том хүн хүүхдээ хөтлөөд явж байгаа бөгөөд жирэмсэн эмийн зургийг цоолборлож гаргажээ. Энэ нь овог задарч гэр бүл /монгол ёс/ нэн эрт үүссэнийг үзэхэд 2 эр хүн өрхийн төдийгүй овогтоо ч нөлөөтэй байж овог ч гэр бүлүүдэд уusan автсаныг өгүүлнэ. Сүг зурагт хүйсийн заагийг заасан байж болно. Уг тамганы тойрог доторх буруу эргэсэн бүтэн хас нь тэрхүү овгийн онго шүтээн, нийтлэг зан заншил, соёлоо, аж амьдралаа агуулан тусгасан бололтой, тамга, зураг сүгийг дураараа эрээчдэггүй хамгийн эрхэм нандин гэсэн газартaa зурж сийлдэг байснаа үйл хөдлөл, ахуй амьдралаа дүрслэх нь их болж түүхэн үнэнийг бидэнд дэлгэж өгч байна. Хас тэмдгийг судлаачид үгийн гарлын хувьд "хатуу", "Батбэх" /С.Дулам/ гэсэн үндсэн утгатай гэсэн байна. Хас нь арга билэг, өргөрөг

<sup>1</sup> Түүхийн судлал, т.XXXII.F.2.УБ., 2003. 14 тал

<sup>2</sup> Т.Санжмятав. Монголын хадны зураг УБ., 1995 .154 тал; Ю.Болдбаатар, Д.Хүүхэнбаатар "Дэл уулын III руна бичээс". МУИС. НУФ.ЭШБ.УБ., 1998 №4 /133/ 191-196 тал, Ц.Баттулга. Дэл Уулын Баруун билүүний II-III бичээс. Археологи судлал. Т.XVII. F- 9, Ц.Баттулга, Ц.Төрбат, Б.Ганчимэг. Дэл уулнаас шинээр олдсон хятад бичээс.МУИС.МХСС.ЭШБ. XVII, УБ., 2001

уртрагийн агуу их орон зай шүтэлцээг дээдлэн агуулжээ. Хадны сүг зургийг сэдэвчлэн ангилбал тамга, дүрс, хүн, гэрийн тэжээмэл амьтад, хесөг тээвэр, нүүдэлчдийн гэр ахуй, ан гөрөө, дайн тулаан, бичгийн дурсгал хэмээн тоймлон ангилж болмоор. Дэл уулын хадны сүг зургийн дотор тамганы дурсгал багагүй байр эзлэх бөгөөд дүрслэлийн хувьд олон янз байна. Тухайлбал: Сам, Онгин, Наран /онгин/, хас Өлзий тэмдгүүд байна. Хас тэмдгийг хосолмол байдлаар дугуй дотор буруу эргэсэн хас байх бөгөөд бусад газраас олдсон тамганаас нэлээд өөр. Тамга хувийн өмчийн таних тэмдэг төдийгүй тамганы эзэн /овог/-ийн бэлчээр нутаг, мал сүргийн нь баталгаа болоод хил байна гэсэн судлаачдийн санал байна.

Зэрлэг ан амьтны тоонд янгир, буга, могоч оруулсан байх юм. Энд чоно, хавтгайг орхисон харагдана. Үржих олширохын бэлэгдэл болгож хүйс ялгах тэмдгийг том, жижиг зурсан байна. Энэ нутаг үнэхээр үлэг гүрвэлээс эхлээд зэрлэг адгуус амьтдын орон байж хулан тахь, барс ирвэс, аврага том могой, мазаалай зэрэг ер бидний юу эс болох үлгэр домгийн амьтны орон байсан байжээ. Энэ газар амьтдын үүсч төрсөн нутаг гэж хэлж болмоор байна. Хөнжлийн ар Худаг сүүжийн толгодыг хараад нэг сэтгэгдэл төрүүлнэ.

Судлаачид хесөг тээврийн тухай ярихдаа монгол орны хад чулуунаа тэрэг, булхайг дүрсэлдэг нь тээврийн хэрэгслийн голлох үргийг гүйцэтгэж байсны гэрч гэсэн байхад негеө нь мөрөөдлийн бэлэг тэмдгийн гэжээ. Үүний аль алиентай нь би санал нийлдэггүй тэрэг голлох биш ч гэсэн аж ахуйд нэвтэрч байсны тодорхой баримт бол Баруун билүүний Хондон толгойн өвч бүрэн тоноглогдсон, эзэн нь залж яваа хоёр дугуйт тэрэгтэй бусад дагалт хэрэглүүн нохой хүртэл байна. Бичгийн дурсгалаас Руни бичээс хятад, түвд, уйгаржин монгол гэмээр бичээс бий. Оюутан судлаач хүүхэд тайлах оролдлогыг хийснийг үзэхэд их хэмжээний ав хомрого хийж олз омогтой яваагаа аж ахуйн зориулалтаар тэмдэглэсэн нь рунийн бусад олдсон бичээсүүдэд байдаггүй гэнэ. Энэ руни бичээсийг хэн хэдий хэдийд зурж бичсэнийг хэлэхэд бэрх. Тэр үедээ соёлтой хэл бичигтэй ирмэл хүмүүс байж гэхээс цаашгүй. Хийд Балгасаас Баруун билүүний хурал /одоо тур/, Чулуун сүм /тур/ хөнжилд Далайн хурал /тур/ гэж байжээ.

Чулуун сүмийг эрдэмтдийн амнаас Цогт хун тайж Хөх нуур руу нүүж явах замдаа тодорхой хугацаанд суурьшсан байж магадгүй гэнэ. Хэд хэдэн байшингийн суурь байх бөгөөд ганц гол сүм нь оройгүй дөрвөн хананы бүрэн бүтэн чулуун өрлөг нь Хар бухынхтай, Цогтын балгастай ижил гэдэг ч хүн бий. Чулуун сүмийн гол барилгыг чулуугаар барьсан гэхэд тун цэмцгэр, хазгай муруйгүй шулуун цэх байгууламж байсан атал хонио хотлуулсаар ханаараа давахад хүрч, түрүү үеийнхний хүндийг цээрлэдэг эрхэм ёсоо умартан балалжээ. Эрдэм судлалын хувьд ганц хоёр карт зурагт тэмдэглэсэн төдий бөгөөд энэ нь эд нар судалгааны хувьд толгой дараагүй бололтой. Сүүлийн жижиг чулуун суврага байсныг би мэдэх юм. Сүг зургаас үзэхэд тэр үеийн хүмүүсийн амьдрахын төлөө ямар их тэмцэж байсныг бэлэхээн хэлээд өгнө. Сүг зургаас хараад тэд мал аж ахуй, эрхлэх, ан гөрөө хийх, өөр хоорондоо тулалдаж байсан нь цаана нь тодорхой хүмүүсүүд яаж тэмцэж, хуягт морин цэрэг, 2 овгийн хоорондоо тулалдаж буйг гаргуун дүрсэлсэн байх нь нэгийг хэлнэ. Одоогийн байдлаар Руни бичиг 4, хятад бичиг 1, Монгол (уйгаржин, манж) 1, Түвд 10 гаруй олдоод байна. II бичээст "Ан автай салаа тэнгэр минь та эзэн нээ, III бичээст "Өтүсийн урт салаа /хоолой/ ариун догшин салаа" гэсэн байх амой. Руни бичгийг их хожуу ирүүл хүмүүс гаргаж, хурц ирт мэсээр зуржээ. Руни бичгийн зарим нэгийг тайлсан залуу эрдэмтдийн судалгаанаас үзэхэд амь зуухын төлөө их ав хомрого олз хишигээ хүртсэнээ бичсэн нь бас түүний цаана хүчит дайчин авчингууд байгааг бас л эзэнтэй, зөрчил тэмцлийг нь өгүүлсэн байна. Бүр сүүлд манай нутгийнхыг Дэлийн хулгайчид гэдэг ёоз муутай нэр

байдгийг нуух юун. Би тэр хулгайчдыг мэдэхгүй. Би ээжтэйгээ хамт Улаан Бандихүү гэгчээс Оргодамба гэгч сайн хулгайч /сайн эр/-ийн тухай дуулсанаа будэг бадаг санаж байна. Дэл хөнжилд хонхор дүүргэн билчдэг малтай манай хүүхнүүдийхэн лав гадагшаа хумслаж буяндаа бузар хийгээгүй байх. Тэдний хэдэн охид нь салбартаа улсын тэргүүн болж, нэг хүү нь доктор, МУИС-ийн хүндэт профессор болсон байх юм. Малчин өрхөөс төрсөн сэхээтнууд гэхээс яахав. Өчүүхэн би өөрсдийнхөөрөө эрдэм шинжилгээний хялбарчилсан нийтлэл өгүүллээ төгсгөж байгаадаа хүлцэл ечье.

Түүхэн үүднээс үзэж харж судалснаа түмэндээ хүртээе.

*Номын буян хишиг оршиг!*

**Abstract:** The article describes the Dal Hunjil rock pictures (petroglyphs) on the territory of Tagt bag of Ulziit som in Dundgobi aimag, as well as other archeological monuments.

### Ном зүй

1. Ц.Баттулга. Дэл Уулын Баруун билүүний II-III бичээс, Археологи судлал. Т.XVII. F- 9,
2. Ц.Баттулга, Ц.Төрбат, Б.Ганчимэг. Дэл уулнаас шинээр олдсон хятад бичээс. МУИС.МХСС.ЭШБ. XVII, УБ., 2001
3. Ю.Болдбаатар, Д.Хүүхэнбаатар “Дэл уулын III руна бичээс”. МУИС. НУФ.ЭШБ.УБ., 1998 №4 /133/
4. А.Лхагва. Ижий суварга. УБ., 2004
- 5.Д.Цэвээндорж, Н.Батболд. Дундговь аймгийн дэл уулын билүүний хадны зураг. УБ., 2005
- 6.Өлзийгөө хайлласан Өлзийт нутаг минь (ред.Д.Нямаа, Т.Сугар). УБ., 2004
- 7.Т.Санжмявав. Монгол хадны зураг УБ., 1995.
- 8.Түүхийн судлал, т.XXXII.F.2.УБ., 2003. 14 тал
- 9.Т.Санжмявав. Монголын хадны зураг УБ., 1995 .154 тал; Ю.Болдбаатар, Д.Хүүхэнбаатар “Дэл уулын III руна бичээс”. МУИС. НУФ.ЭШБ.УБ., 1998 №4 /133/ 191-196 тал, Ц.Баттулга. Дэл Уулын Баруун билүүний II-III бичээс, Археологи судлал. Т.XVII. F- 9, Ц.Баттулга, Ц.Төрбат, Б.Ганчимэг. Дэл уулнаас шинээр олдсон хятад бичээс. МУИС.МХСС.ЭШБ. XVII, УБ., 2001